



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 1/23

Чингис хот

Комисс томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэрлэн сумын 1, 5 дугаар багт ухаалаг худаг байгуулах ажлыг хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Г.Батгэрэл	-“Хэнтий-Ус” ХХК-ий гүйцэтгэх захирал
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Бямбасүх	-“Хэнтий-Ус” ХХК-ий ашиглалтын инженер
	Д.Эрдэнэбат	-“Хэнтий-Ус” ХХК-ий ерөнхий нягтлан бодогч

2. Ажлыг техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагын дагуу хүлээн авахыг комиссын дарга /Г.Батгэрэлд/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР